

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.04 №46 (46)

ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧИН АЛТАН МӨРДЭСТНҮҮДИЙНХЭЭ ЭГНЭЭГ ТЭЛЛЭЭ

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга 3 дугаар сарын 18-ны өдөр Цэргийн дээд цол хүртээх тухай зарлиг гаргасан билээ.

Тэгвэл тус зарлигийн дагуу цэргийн дээд цол гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн Их танхимд болж, цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга гардуулав. Тодруулбал, хошууч генерал цолыг ОБЕГ-ын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр нарт, бригадын генерал цолыг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг, ЗХЖШ-ын Нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар, Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа С.Ганбат, ХХЕГ-ын дэд дарга, хурандаа Д.Ганбаатар, ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр, ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, хурандаа М.Мөнхбаяр, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Б.Баатар, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, хурандаа

Д.Баасандамба, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Д.Дамдинцэрэн нарт тус тус хүртээлээ.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга хэлсэн үгэндээ, “Төрийн тусгай албад бол нийгмийн амар амгалан байдлыг сахин хамгаалах, эрсдэлт нөхцөлд тушаалаар үүрэг гүйцэтгэдэг онцгой үүрэг, хариуцлагатай салбар. Эдгээр салбарыг удирдаж, албаны үүрэг даалгаврыг чанд биелүүлж, улс төржилтөөс ангид байж, нийгэмдээ, ард иргэддээ үйлчлэх тангаргаа хэлбэрэлтгүй сахин биелүүлж байдаг тань ард олныхоо өмнөөс талархал илэрхийлье. Та бүхэн төрийн тусгай албад олон жил үр бүтээлтэй ажилласан, цолныхоо шаардлагад тэнцсэн хүмүүс. Генерал цол бол нэн хүндтэй цол, бас үүрэг хариуцлага юм шүү. Цолыг даган ирж байгаа хүндэтгэл, итгэлийг дааж цолондоо тэнцэхүйц ёс зүй, хичээл зүтгэлтэй ажиллах даалгавар давхар ирж байгааг цаг үргэлж санаж яваарай хэмээн захъя” хэмээн онцлоод шинэ генералуудад ажлын амжилт хүссэн юм. Ташрамд дурдахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар бригадын генерал цол хүртэж буй Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, хурандаа Б.Эрдэнэбат БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны Жуба бүсийн командлагчаар үүрэг гүйцэтгэж байгаа билээ.



ТҮҮХЭН ОЙНУУДЫН ДАВХЦАЛ, УУЛЗВАР ДЭЭР ГЕНЕРАЛ ЦОЛ ХҮРТСЭНДЭЭ БАЯРТАЙ БАЙНА



БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.ГАНХУЯГ:

-Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Батлан хамгаалах яамны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100, цэргийн эрхэм дээд цол болох генерал цол олгож эхэлсний 77 жил гээд түүхэн ойннуудын давхцал, уулзвар дээр генерал цол хүртсэндээ баяртай байна. Хүний амьдралд хэзээ ч мартагдашгүй, дурсамж дүүрэн үйл явдал олон тохиодог. Миний хувьд 1999 онд БХИС-ийг онц дүн, улаан дипломтой Н.Багабанди гуайгаас шинэхэн дэслэгч дипломоо гардан авч байлаа. Тэр цаг мөчөөс буюу сонсогчийн казарам, оюутны ширээнээс ажил амьдралын их талбарт хөл тавьж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчиндээ 26 жил хоёргүй сэтгэлээр хөдөлмөрлөн өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 39 дүгээр зарлигаар цэргийн дээд цол хүртлээ. Энэ өдөр бол миний амьдралд бас нэг тод өнгө нэмсэн, том дурсамж хадгалсан мартагдашгүй өдрүүдийн нэг байх нь гарцаагүй.

Мэдээж цол дагаж асар их хариуцлага ирж байгаа. Тийм учраас салбарынхаа төлөө өөрт байгаа бүхий л боломжоо дайчлан ажиллах болно. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин бол энхийн цагт үүргээ нэр төртэй гүйцэтгэхийн зэрэгцээ эх орны энх цагийн бүтээн байгуулалтад голлох үүрэгтэй оролцож байна. Тэр ч чанараараа манай салбарын боловсон хүчнүүд чадварлаг гэдгээ батлан харуулж байгаа юм. Тэгэхээр энэ салбараар овоглож яваа хэн бүхэнд зангидсан гар шиг байж, хамтдаа илүү ихийг бүтээхийн төлөө ажиллацгаая гэж уриалъя.

ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭР ОВОГЛОЖ ЯВААГААРАА ЭРХГҮЙ БАХАРХЛАА



Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.БААТАР:

-Юуны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар цэргийн дээд генерал цол хүртсэндээ баяртай байна. Миний хувьд 1997 онд ЦИС-ийн Ерөнхий цэргийн курсыг Ерөнхий цэргийн команд штабын офицер мэргэжлээр дүүргэсэн. Энэхүү эрхэм хүндтэй цолыг хүртэж байх агшинд Зэвсэгт хүчинтэй ажил амьдралаа холбож, энэ салбараар овоглож яваагаараа эрхгүй бахархаж байлаа. Мөн асар их үүрэг хариуцлага, итгэл хүлээлгэж энэ цолыг хүртэж байгаа нь ойлгомжтой. Би Зэвсэгт хүчинд алба хаах хугацаандаа ихэвчлэн тусгай батальонуудад алба хашиж, улмаар Тусгай хүчний цэргийн командлагчаар томилогдон ажиллаж байна. Шинэ тутам байгуулагдаад байгаа энэхүү командлалыг командлалын дайтай авч явах, Зэвсэгт хүчин тэр тусмаа тусгай хүчний нэр хүндийг өндөрт өргөж явах нь бидний эн тэргүүний зорилго. Тийм ч учраас бид тусгай хүчний алба хаагчдын ёс зүй, бие бялдар, цэргийн сургалт бэлтгэлээс эхлээд төрдөө, Зэвсэгт хүчиндээ, ажил албандаа үнэнч, цэргийн хүний ёс суртахуунтай, зөв хандлагатай, зөв төлөвшилтэй, мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнийг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.

Энэ ташрамд намайг бүхий л талаар дэмжиж тусалж ирсэн удирдлага, хамт олон, онжавууддаа, бас ажлаа хоёргүй сэтгэлээр хийх боломж нөхцөлийг бүрдүүлж, найдвартай ар тал байж чаддаг гэр бүлдээ баярлаж байгаагаа илэрхийлье.

АСАР ИХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЛЭЭ



ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.ЖАВХЛАНБААТАР:

-Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар цэргийн дээд генерал цол хүртсэндээ маш их баяртай байна. Генерал цолны зарлиг уншиж байх агшинд хамгийн түрүүнд Зэвсэгт хүчин хэмээх их айлын халуун ам бүлд багтан ажил амьдралаа холбож, хоёргүй сэтгэлээр 28 жил зүтгэсэнээрээ бахархах сэтгэл төрж байлаа. Үүний зэрэгцээ хувь хүний хувьд ч, байгууллагын хувьд ч бидэнд асар их үүрэг хариуцлага хүлээлгэж байна гэдгийг ч ухамсарлаж зогслоо.

Мөн Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохиож буй энэхүү түүхэн цаг үед алба хааж байгаагаараа бахархаж байна. Ер нь бид бүхэн энэхүү түүхэн цаг үед Зэвсэгт хүчинээрээ овоглон нэгэн хамт олон болж, мөр зэрэгцэн алба хааж байгаагаараа бахархах ёстой. Басхүү нэгэн зууны түүхтэй Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөх нь бидний хамгийн том үүрэг гэдгийг ухамсарлах учиртай. Тийм ч учраас Зэвсэгт хүчнийхээ нийт бие бүрэлдэхүүнд үүрэг хариуцлагатай биелүүлэхийг уриалъя. Салбарын маань ирээдүйн өнгө төрх, хөгжил дэвшил өнөөдөр алба хашиж байгаа та биднээс ихээхэн хамааралтай учраас тэр шүү дээ.

Бид стратегийн төлөвлөлт, хөгжлийн бодлогын томоохон баримт бичгүүдийг батлуулсан. Эдгээрийнхээ хэрэгжилтийг хангахын тулд байлдагчаасаа генерал хүртэл бүгд хичээх ёстой. Энэ ташрамд итгэл хүлээлгэж эрхэм хүндтэй цол хүртээсэн хамт олондоо, Зэвсэгт хүчнийхээ нийт бие бүрэлдэхүүнд чин сэтгэлийн халуун талархлаа илэрхийлье.

ЦААШИД БҮХ ХҮЧЭЭ ДАЙЧЛАН ХИЧЭЭЖ АЖИЛЛАХ БОЛНО



Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, бригадын генерал Д.БААСАНДАМБА:

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн дээд цол хүртсэндээ туйлын баяртай байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлага өргөн хүрээтэй, өндөр хариуцлагатай болж буй энэ цаг үед надад итгэл хүлээлгэлээ. Зэвсэгт хүчинд 28 дахь жилдээ алба хааж байна. Энэ хугацаанд хамтран ажиллаж, туслаж дэмжиж, заан сургаж байсан шилдэг хамт олондоо баярлалаа.

Цолоо гардаж авах гэж агшинд аав, ээж хоёр минь яаж баярлаж байгаа бол доо гэж бодогдсон. Тэднийхээ итгэлийг алдалгүй өдий зэрэгтэй явж байгаагийн маань илэрхийлэл бол энэ цолыг хүртэж буй явдал юм болов уу гэж бодож байна.

Кибер аюулгүй байдлын цэргийн командлал өмнөө тавьсан зорилго, цаашид Монгол Улсын аюулгүй байдлын урт болон дунд хугацааны зорилтод тулгуурласан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна хүний нөөцөө бэлтгэх, технологийн шинэчлэл хийх зэрэг олон шат дараатай ажлыг төлөвлөсөн. Цаашид бүх хүчээ дайчлан, хичээж ажиллах болно.

МИНИЙ ХҮҮ ААВЫНХАА НЭРИЙГ МОНГОЛ ТӨРИЙНХӨӨ ӨМНӨ ДУУРСГАЛАА

ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, бригадын генерал М.МӨНХБАЯР:

-Төр, ард түмнийхээ итгэлийг хүлээж цэргийн дээд цол хүртсэндээ маш их баяртай байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаасаа генерал цол гардан авах үед энэ хүндтэй цолны нэр хүндийг дагаад том үүрэг, хариуцлага нэмэгдэж буйг ойлгосон. Энэхүү үйл явдал миний амьдралд тохих хамгийн үнэ цэнтэй мөч болон дурсагдах болно.

Генерал цол хүртэх болсноо аав ээж рүүгээ утасдаж хэлэхэд аав минь “Миний хүү аавынхаа нэрийг Монгол төрийнхөө өмнө дуурсгалаа” гэж үнэхээр баярлаж байгаа нь мэдрэгдэж байсан. Цаашид Монгол Улс, ард түмнийхээ эрх ашиг, тусгаар тогтнол, батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн эх орныхоо төлөө зүтгэх болно.

ГЕНЕРАЛ ЦОЛЫГ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР ОРОНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙХДАА ХҮРТСЭН АНХНЫ ОФИЦЕР БОЛЛОО

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, бригадын генерал Б.ЭРДЭНЭБАТ:

-Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга Цэргийн дээд цол хүртээх тухай зарлиг гаргасныг Монгол Улсад генерал цол бий болсны 77 жилийн ой, “Монгол генералын өдөр” буюу 4 дүгээр сарын 28-нд нийтэд танилцууллаа гэсэн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдахтай зэрэгцээд танилууд маань баяр хүргэж цахим шуудан илгээхэд генерал цол хүртэж байгаагаа мэдсэн. Түүхт ойннууд давхацсан, бэлгэ дэмбэрэлтэй өдөр цэргийн дээд цол хүртэж байгааг мэдээд маш их бэлгэшээж баярласан. Монгол Улсынхаа Зэвсэгт хүчинд тасралтгүй 29 жил алба хаахдаа хоёргүй сэтгэлээр зүтгэж, өөрт даалгаврыг чин сэтгэлээсээ гүйцэтгэж ирсэн хөдөлмөр зүтгэлийг маань төр засаг, цэргийн дээд удирдлага, цэргийн эрдмийг зааж сургасан эрхэм багш нар, удирдлагад нь алба хааж байсан үе үеийн захирагч, дарга нар, хамт олны дэмжлэг, хамтын хөдөлмөр ивээж генерал хэмээх эрхэм дээд цолтон болголоо. Мөн дэлхийн халуун цэгүүдэд мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэн болон гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулагчдын маань олон жилийн хүч хөдөлмөр асар их дэм болсон гэдгийг онцломоор байна. Төрүүлж өсгөсөн ээж аав, өдий зэрэгтэй хүмүүжүүлсэн өвөө болон хань, үр хүүхдийн минь түшиг тулгуур албаа хаахад минь ихээхэн дэмжлэг болсон гэж боддог. Асар их үүрэг, хариуцлага даалгахын хамт цаашид ахмад үеийнхнийхээ сургаалийг сонсож, шинэ үеийн шинэлэг санал санаачилгыг тусган Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшлийн төлөө ихийг хийж бүтээх урам зориг өглөө. Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 2002 оноос энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэнээс хойш бага, дунд, ахлах офицеруудын цолыг ажиллагааны газар оронд олгож байсан. Харин Цэргийн дээд цолыг ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байхдаа хүртсэн анхны офицер болж байгаадаа баяртай байна. Энэ завшааныг ашиглаад алтан мөрдөст генералууддаа эрүүл энх, сайн сайхныг хүсэн өрөөе. Монгол Цэргийн сүлд хийморь мөнхөд ивээг.

Монгол Улсынхаа төлөө зүтгэе!



ЦАХИМ ШУУДАНД



Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Халиунсумынхарьяатбайлдагч Ц.Үржинханд, Н.Бямбадорж, Тайшир сумын харьяат М.Арсланбямба, Есөнбулаг сумын харьяат Г.Батмөнх, Л.Баасандорж Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба нэр төртэй, үлгэр жишээчээр хаагаад халагдан нутагтаа ирлээ. Тэд алба

хаах хугацаандаа хамт олноо сахилга бат, ажил хөдөлмөрөөрөө манлайлсан тэргүүний алба хаагчид бөгөөд Л.Баасандорж нь тус ангидаа, Ц.Үржинханд, М.Арсланбямба нар Төрийн тусгай албаны ахлагчийн албанд шилжин ажиллахаар болсон байна. Мөн тэднийг аймгийн Онцгой байдлын газраас ажиллах санал тавьсан юм.

Ахмад Г.МӨНХБАЯР



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Өмнөговь аймгийн харьяат 10 байлдагч Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагаад ирлээ. Тэд алба хаах хугацаандаа төрийн болон бусад ёслолын үйл ажиллагаанд оролцсоноороо, мөн Төрийн торгон цэргийн ангид алба хааснаараа бахархаж буйгаа илэрхийлж байв. Хилийн цэргийн ангид алба хаасан бүрэлдэхүүн энэ сарын 9-ний өдөр ирнэ.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨНӨӨР ДАРХЛААГА ДЭМЖИНЭ

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Бие бүрэлдэхүүнийхээ бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, биеийн жингийн зохистой харьцааг хангуулах, дасгал хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжих хүрээнд “Унадаг дугуйг сонго” уриаг дэвшүүлэн ажиллаж байна.

Автомашинаас татгалзаж, унадаг дугуйг хэрэглээ болгох алба хаагчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 30 орчим цэргийн алба хаагч энэ аянд нэгджээ. Ангийн удирдлагаас энэхүү аяныг дэмжиж, ангийн байрлалд дугуйн зогсоол шинээр байгуулж, засвар үйлчилгээг хэрхэн явуулах талаарх сургалтыг ч явуулж хэвшсэн.



Дугуй унах нь эрүүл мэндийн хувьд олон талын ач холбогдолтойгоос гадна эдийн засаг болоод цаг хэмнэхэд чухал үүрэгтэй юм.

Ахлах дэслэгч Э.УУГАН-ЭРДЭНЭ

ХӨЛ ХОРИОГ СУЛЛАЖ, ААН-ҮҮДЭЭ ШАТ ДАРААТАЙ НЭЭНЭ



Энэ сарын 8-ны өдрөөс эхлэн хөл хориог суллаж, ААН-үүдээ шат дараатай нээхээр төлөвлөж байна гэж УОК-ын хэвлэлийн төлөөлөгч Ц.Ганзориг мэдээллээ. Вакцинжуулалт, халдвар хамгааллын дэглэмээ хүн бүр барих нь чухал байгааг албаны хүмүүс хэлж байгаа

юм. Өнгөрсөн 24 цагийн хугацаанд улсын хэмжээнд “Ковид-19”-ын эсрэг вакцинд 94.946 хүн хамрагджээ. Үүнээс нийслэлийн хэмжээнд 52.082, аймаг орон нутагт 42.864 иргэнийг вакцинжуулалтад хамруулсан байна.

ХИЛИЙН ЧАНАДААС

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН САРЫН ТЭРГҮҮНҮҮД ТОДРОВ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын UNMISS энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа Д.Энхбаатар захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн өнгөрсөн сарын 30-нд дөрөвдүгээр сард гүйцэтгэсэн ажлаа дүгнэж, сахилгын дүнгийн хурлаа хийж, төгсгөлд нь Цэргийн тангараг давтах ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Цэргийн багаас тухайн

сард бүтээлч хандлагаараа хамт олноо манлайлж, цэргийн алба, үүрэг гүйцэтгэлт, сахилга, зохион байгуулалтаараа шалгарсан бүрэлдэхүүнээ “Тэргүүний салаа”, “Тэргүүний тасаг”, “Тэргүүний офицер”, “Тэргүүний ахлагч”, “Тэргүүний шинийг санаачлагч бүтээлч алба хаагч” хэмээн өргөмжилж, шагнаж урамшуулдаг уламжлалтай. Дөрөвдүгээр сарын “Тэргүүний салаа”-гаар захирагчтай

гуравдугаар мотобуудлагын салаа, “Тэргүүний тасаг”-аар ахлах ахлагч Э.Эрдэнэбаатар захирагчтай гуравдугаар мотобуудлагын тасаг, “Тэргүүний офицер”-оор дотрын их эмч, ахлах дэслэгч Б.Баярбат, “Тэргүүний ахлагч”-аар чирэгчийн жолооч, дэд ахлагч Ц.Цэрэнтогтох, “Тэргүүний шинийг санаачлагч, бүтээлч алба хаагч”-аар буудагч, дэд ахлагч Г.Бат-Эрдэнэ нар шалгарлаа.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД



МИНИ МАРШ

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Энэ сарын 1-2-ны өдрүүдэд хугацаат цэргийн алба хаагчдын дунд ерөнхий цэргийн хамгаалалт, химийн иж өмсөх, өгөгдсөн даалгавар биелүүлэх, гранат шидэлт, ерөнхий цэргийн саадыг бага хугацаанд амжилттай туулах зэрэг тэмцээнийг явуулж, шилдгүүдээ тодрууллаа.

Уг тэмцээнд 150 гаруй хугацаат цэргийн алба хаагч оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорьсоноос химийн иж өмсөх норматив биелүүлэх тэмцээнд байлдагч Э.Ганзориг, Х.Давааням, Д.Мөнхбат нар энхийн байруудад шалгарлаа. Гранат шидэлтийн төрөлд байлдагч Б.Эрдэнэхүү, Л.Сумъяабазар Х.Цогтсайхан нар шалгарсан бол ерөнхий цэргийн саадыг туулах, цэргийн

хэргийн мэдлэг сорих ганцаарчилсан төрөлд Д.Ариунболд, н.Баярцогт, И.Сэрээтэр нар тэргүүн байрыг эзлэв. Мөн Ерөнхий цэргийн саадыг туулах, цэргийн хэргийн мэдлэг сорих шилдэг тасаг шалгаруулах тэмцээнд ТЭАБ тасаг, Артиллерийн дивизионы 152мм батареины тасаг, Тийрэлтэт артиллерийн дивизионы тасаг тус тус шагналт байрын эздээр тодорлоо.

Тэмцээнд оролцсон алба хаагчид болон үзэгч дэмжигчдэд ерөнхий цэргийн мэдлэг чадвар олгох сургалтыг соёл хүмүүжлийн

ЗОХИОН БАЙГУУЛАВ



офицер, ахмад П.Бэхбат явуулсан ба амжилттай оролцсон алба хаагчдыг шагнаж урамшууллаа. Тэмцээний дараа 2021 онд шинээр гарсан уран сайхны кино үзүүлсэн юм.

Дэслэгч Б.БАТТУЛГА